



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgov@audit.gov.mn

2016-11-07 № 01/164

ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ДАШТОГОХ ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар нийт 3,551,184.00 /Гурван сая таван зуун тавин нэгэн мянга нэг зуун наян дөрөв / төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын олговор тооцоходоо нэг өдрийн дундаж цалин хөлсийг буруу тодорхойлсноос 34 ажилтанд нийт 3,551,184.00 төгрөгийг дутуу олгосон.

Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2003 оны 166-р тушаалын 2-р хавсралтын 4 /Ээлжийн амралтын олговрыг тодорхойлоходоо амралт олгохын өмнөх 12 сарын цалин хөлсний нийлбэрийг 12-т хувааж нэг сарын дундаж цалин хөлсийг гаргах бөгөөд гарсан тоог байгууллага, нэгжид мөрдөж буй ажлын өдрийн тоонд хувааж нэг өдрийн дундаж цалин хөлсийг тооцож гаргана. Нэг өдрийн дундаж цалин хөлсийг ажилтны ээлжийн амралтын өдрөөр үрэсүүлэн ажилтанд олговол зохих ээлжийн амралтын олговрын хэмжээг тодорхойлно./ заалтыг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:


1001000712

1. Ээлжийн амралтын олговрыг тооцоходо холбогдох дүрэм журмыг баримталж, дундаж цалинг зөв тооцож байх, нэр бүхий ажилтнуудын амралтын олговорын дутууг тайлангийн хугацаанд нөхөн олгож хохирлыг барагдуулах
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 01-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Даштогтох/, нягтлан бодогч /Д.Билэгсайхан/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

Шинжээч



С.Жалбаа

ЗӨВШӨӨРСӨН:

Захирал

Б.Даштогтох

Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургууль:

Нягтлан бодогч

Д.Билэгсайхан

A handwritten signature in blue ink, appearing to read "Нягтлан бодогч".

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд тушаалтанд хүргүүлнэ” ээж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.